



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/128

Ховд

Гамшгаас хамгаалах сургууль, дадлага
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.6, Гамшгаас хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.8, 32.1.10, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослоос хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчин мал амьтныг хамгаалах, эрэн хайх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх үйл ажиллагаанд хүн амыг сурган дадлагажуулах, хүч хэрэгслийн харилцан ажиллагааг зохион байгуулах, гамшгаас хамгаалах төлөвлөгөө, сургуулийн бодлого, удирдамжийг хэрэгжүүлэх зорилгоор “Гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургууль”-ийг Дуут, Алтай, Чандмань, Цэцэг, Эрдэнэбүрэн сумдад, “Гамшгаас хамгаалах команд штабын дадлага сургууль”-ийг Үенч, Дарви, Мөнххайрхан, Булган, Дөргөн сумдад 2019 оны 2, 3 дугаар улиралд багтаан зохион байгуулахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа /Б.Алтанбадралт/ дээрх сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2. Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлагын бэлтгэл ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, дадлага, сургууль явуулах удирдамжийг хоёрдугаар, танхимын сургалтын хөтөлбөрийг гуравдугаар, шаардагдах зардлыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

02.00576

D/Zax-A/128-Da

3. Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлагад орон нутгаас оролцох хүн хүч, техник хэрэгслийн нөөцийг бүрдүүлэн, бэлтгэлийг хангаж ажиллахыг Эрдэнэбүрэн, Булган, Чандмань, Мянгад, Мөст, Манхан, Зэрэг, Дарви, Цэцэг, Мөнххайрхан сумдын Засаг дарга нар, аж ахуйн нэгж байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

4. Гамшгаас хамгаалах сургууль, дадлага зохион байгуулахад шаардагдах 7525710 /төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



The stamp is rectangular with a red border. Inside, there is a central emblem featuring a flame above a circular base. On either side of the emblem, there is vertical text in Mongolian script. A handwritten signature in black ink is written across the center of the stamp.

Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны
02 дугаар сарын 28-ны өдрийн
А/128 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ ДАДЛАГА СУРГУУЛИЙН
БЭЛТГЭЛ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хүн ам, эд хөрөнгийг гамшгийн аюулаас авран хамгаалах, сэргээн босгох арга ажиллагаанд сум орон нутгийн мэргэжлийн анги, ажилтан, албан хаагчид, иргэдийг сургаж дадлагажуулахад оршино.

д/д	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Дадлага сургууль явуулах тухай аймгийн Засаг даргын захирамжийг сумдад хүргүүлж, бэлтгэл ажлыг хангуулах	1 дүгээр улиралд	Ахлах дэслэгч Б.Одгэрэл
2	Дадлага сургууль явуулах сумдын мэргэжлийн анги, албадуудын томилгоог хийх, баталгаажуулах	1 дүгээр улиралд	Сумдын Засаг дарга, Ахмад П.Бямбадорж
3	Дадлага сургуулийн холбогдох бичиг баримт, техник хэрэгслийг бэлтгэх, хичээл заах багш нарын цаг сэдвийн төлөвлөгөөг боловсруулж, баталгаажуулах	1 дүгээр улиралд	Ахмад П.Бямбадорж Ахлах дэслэгч Б.Одгэрэл
4	Сумын командын байр бэлтгэх, дадлага сургууль явуулах бэлтгэл, сургалтын танхим бэлтгэх	1 дүгээр улиралд	Сумдын Засаг дарга, Ахмад П.Бямбадорж
5	Тухайн сумдад сүүлийн 10 жилийн хугацаанд тохиолдсон гамшгийн судалгаа гаргах	1 дүгээр улиралд	Хошууч Д.Очирбадам,
6	Сумдын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, шинэчлэн боловсруулах	1 дүгээр улиралд	Сумдын Засаг дарга, Ахмад П.Бямбадорж
7	Гамшгийн төрөл тус бүрээр сурталчилгааны материал, сэрэмжлүүлэх хуудас бэлтгэх	1 дүгээр улиралд	Ахлах дэслэгч Б.Одгэрэл
8	Сумдын Онцгой комисс, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн анги, ард иргэдийн судалгааг гаргах	1 дүгээр улиралд	Ахмад П.Бямбадорж
9	Сумдын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, шинэчлэн боловсруулах	Тухай бүрт	Сумдын Засаг дарга, Ахмад П.Бямбадорж
10	Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, үйл ажиллагааг орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах	Тухай бүрт	Ахлах дэслэгч Б.Одгэрэл
11	Сумдын иргэдийн оролцоотойгоор эрсдэлийн үнэлгээ хийх, зураглал гаргах	Тухай бүрт	Сумдын Засаг дарга, Хошууч Д.Очирбадам
12	Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлаж гамшигтай тэмцэх ажлын төлөвлөлт хийх	Тухай бүрт	Сумдын Засаг дарга, Хошууч Д.Очирбадам

Аймгийн Засаг даргын 2019 оны
02 дугаар сарын 28-ны өдрийн
А/128 дугаар захирамжийн
2 дугаар хавсралт

УДИРДАМЖ

Гамшгаас хамгаалах дадлага сургуулийн тухай

Аймгийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/128 дугаар захирамжийн дагуу гамшгаас хамгаалах Иж бүрэн болон команд штабын сургуулийг 2019 оны 2, 3 дугаар улиралд лекц, штабын сургууль, аврах ажиллагааны дадлага гэсэн үндсэн 2 үе шаттайгаар зохион байгуулан явуулна.

СУРГУУЛИЙН БЭЛТГЭЛ ҮЕ

Сургуулийн холбогдох бичиг баримт, техник хэрэгслийг бэлэн болгох, хичээл заах багш нарын цаг сэдвийн төлөвлөгөөнд боловсруулалт хийх, хянах, баталгаажуулах.

Сумын командын байр, сургууль явуулах сургалтын танхим бэлтгэх.

Сумдын мэргэжлийн анги, албадуудын томилгоог хийх, баталгаажуулах.

Тухайн сумдад сүүлийн 10 жилийн хугацаанд тохиолдсон гамшгийн судалгаа гаргах.

Сумдын Онцгой комисс, гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, ард иргэдийн судалгаа гаргах.

СУРГУУЛИЙН 1 ДҮГЭЭР ҮЕ / Сургалт, сурталчилгаа/

Оролцох бүрэлдэхүүн : Сумын Онцгой комисс, ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, албадуудын бүрэлдэхүүн, багийн Засаг дарга, аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч

Онцгой байдлын газрын болон холбогдох байгууллагын дарга мэргэжилтнүүд дараах сэдвүүдээр танхимийн сургалт зохион байгуулна.

1. Гамшгаас хамгаалах албад, аж ахуйн нэгж байгууллага, мэргэжлийн анги, удирдах албан тушаалтан, иргэдийг удирдлага зохион байгуулалтаар хангах ажиллагаа - 40 минут
2. Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм, - 40 минут
3. Гамшгаас хамгаалах тухай хууль - 40 минут
4. Мэргэжлийн ангийн дүрэм – 40 минут
5. Малын гоц халдварт өвчний үед хорио цээр, хязгаарлалтын бүс тогтоох, үйл ажиллагаа явуулах журам - 40 минут
6. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс баталсан хүн нэг бүрийн үүргэвчинд байх зүйлс - 40 минут
7. Гамшгийн голомтод холбоо зохион байгуулах, мэдээ мэдээлэл дамжуулах журам - 40 минут
8. Эрэн хайх, аврах ажиллагааны журам – 40 минут

СУРГУУЛИЙН 2 ДУГААР ҮЕ / Цагийн байдал үнэлж,
шийдвэр гаргаж, илтгэл сонсох , биетээр үзүүлэх
дадлага хийх, дүн гаргах/

1. Сумын Онцгой комисс, ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, албадуудын удирдах бүрэлдэхүүнийг “ЯАРАЛТАЙ ЦУГЛАР” дохиогоор цуглуулан цагийн байдал өгч, шийдвэр гаргуулах, илтгэл сонсох, дүгнэлт хийх.
2. Сумын Ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн үйл ажиллагаа;
а/ Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, өөрийгөө болон бусдыг аврах ажиллагаа;
б/ Сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн анги гамшгийн голомтод аврах ажиллагаа явуулах үзүүлэх сургууль;
3. Сум, байгууллага, ард иргэдийг гамшгийн голомтоос аюулгүй бүсэд нүүлгэн шилжүүлэх ажиллагаа;
4. Дээрх ажиллагааг бүрэн явуулж дуусгаснаар “Гамшгаас хамгаалах дадлага сургууль” өндөрлөнө;

СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЛБА ХААГЧИД

- Г.Нэргүй - Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх хяналтын тасгийн дарга, хошууч
- П.Бямбадорж – Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, ахмад
- Д.Очирбадам – Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, хошууч
- Г.Ганжаргал – Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын
Гал түймрийн улсын хяналтын байцаагч, дэслэгч
- Б.Одгэрэл – Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын Ангиллын сургалт, сурталчилгаа урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, ахлах дэслэгч
- Б.Ганцогт - Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах ангийн бүлгийн дарга
- Г.Энхзаяа - Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах ангийн эмнэлгийн зааварлагч
- Я.Эрэмгийбаатар – Булган сум дахь Онцгой байдлын хэлтэсийн дарга, дэд хурандаа
- Б.Оюунбадрах – Булган сум дахь Онцгой байдлын хэлтэсийн Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад
- Б.Азжаргал- Булган сум дахь Онцгой байдлын хэлтэсийн Ангиллын сургалт, сурталчилгаа урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, дэслэгч
- Ц.Чунагсүрэн – Зэрэг сум дахь Гал түймэр унтраах, аврах ангийн дарга ахмад

Аймгийн Засаг даргын 2019 оны
02 дугаар сарын 28-ны өдрийн
А/128 дугаар захирамжийн
3 дугаар хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ ДАДЛАГА
СУРГУУЛИЙН ХӨТӨЛБӨР

Д/д	Сэдэв	Хугацаа	Хичээлийн байр	Хариуцах эзэн
1	Гамшгаас хамгаалах албад, аж ахуйн нэгж байгууллага, мэргэжлийн анги, удирдах албан тушаалтан, иргэдийг удирдлага зохион байгуулалтаар хангах ажиллагаа	40 минут	Танхимд	Хошууч Г.Нэргүй
2	Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм,	40 минут	Танхимд	Хошууч Д.Очирбадам Ахмад П.Бямбадорж
3	Гамшгаас хамгаалах тухай хууль	40 минут	Танхимд	Ахмад П.Бямбадорж
4	Мэргэжлийн ангийн дүрэм	40 минут	Танхимд	Ахмад П.Бямбадорж
5	Малын гоц халдварт өвчний үед хорио цээр, хязгаарлалтын бүс тогтоох, үйл ажиллагаа явуулах журам	40 минут	Танхимд	Эмч Б.Оюун
6	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс баталсан хүн нэг бүрийн үүргэвчинд байх зүйлс	40 минут	Танхимд	Ахлах дэслэгч Б.Одгэрэл
7	Гамшгийн голомтод холбоо зохион байгуулах, мэдээ мэдээлэл дамжуулах журам	40 минут	Танхимд	Ахлах дэслэгч Б.Даваазаяа
8	Эрэн хайх, аврах ажиллагааны журам	40 минут	Танхимд	Хошууч С.Даваажаргал

Аймгийн Засаг даргын 2019 оны
02 дугаар сарын 28-ны өдрийн
А/128 дугаар захирамжийн
4 дүгээр хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ ДАДЛАГА СУРГУУЛИЙН ТӨСӨВ

Явах автомашин: ОБГ-ын фургон автомашин

Шатахуун зарцуулалт: 100км-т 20л бензин А-92: 2015 төгрөг

ГАМШГААС ХАМГААЛАХ ИЖ БҮРЭН ДАДЛАГА
СУРГУУЛИЙН ШАТАХУУНЫ ЗАРДАЛ

Д/д	Явах чиглэл	Нийт км	Хэмжих нэгж	Шатахуун зарцуулалт	Нийт шатахууны зардал /төг/
1	Ховдоос- Чандмань сум Чандмань сумаас-Ховд	330 км /2 удаа/	л	66	138930
2	Ховдоос-Дуут сум Дуут сумаас-Ховд	140 км /2 удаа/	л	28	58940
3	Ховдоос –Алтай сум Алтай сумаас-Ховд	600 /2 удаа/	л	120	252600
4	Ховдоос-Цэцэг сум Цэцэг сумаас-Ховд	520 /2 удаа/	л	104	218920
5	Ховдоос-Эрдэнэбүрэн Эрдэнэбүрэн сумаас -Ховд	140 /2 удаа/	л	28	58940
6	Нийт	1730 км	л	346	728330

ГАМШГААС ХАМГААЛАХ КОМАНД ШТАБЫН
ДАДЛАГА СУРГУУЛИЙН ШАТАХУУНЫ ЗАРДАЛ

Д/д	Явах чиглэл	Нийт км	Хэмжих нэгж	Шатахуун зарцуулалт	Нийт шатахууны зардал /төг/
1	Ховдоос- Дөргөн сум Дөргөн сумаас-Ховд	220 км /2 удаа/	л	44	92620
2	Ховдоос-Дарви сум Дарви сумаас-Ховд	420 км /2 удаа/	л	84	176820
3	Ховдоос –Мөнххайрхан сум Мөнххайрхан сумаас-Ховд	340 /2 удаа/	л	68	143140
4	Ховдоос- Үенч сум Үенч сумаас-Булган сум	400 км	л	80	168400
5	Булган сумаас –Ховд	400 км /2 удаа/	л	80	168400
6	Нийт	1780 км	л	356	749380

БАЙР, ТОМИЛОЛТЫН ЗАРДАЛ

- Нийт томилолтоор ажиллах хоногийн тооцоо- 21 хоног
Томилолтын зардал: 21 хоног x 12000 төг x 9 хүн = 2268000 төг
Байрны хөлс: 21 хоног x 20000 төг x 9 хүн = 3780000 төг
Бүгд: 2268000 төг + 3780000 төг = 6048000 төг
- Бүгд дүн: 728330 төг + 749380 төг + 6048000 төг = 7525710 төгрөг